



ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГУУДАД

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,
http://www.nccd.gov.mn

2023. 10. 12 № 4/1581

танай _____-ны № _____-т

Үнийн санал ирүүлэх тухай

Тус төвийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны зохистой төлөвлөлтийг хийх шаардлагатай байгаа тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийг хүртэл хугацаанд зөвлөх үйлчилгээний үнийн санал ирүүлнэ үү.

Холбогдох материалын бүрдлийг ханган, саналыг tender@nccd.gov.mn хаягаар албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт ³ хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.БАЙГАЛМАА

ХӨСҮТ-ийн 2023 оны 11 дугаар
албан бичгийн хавсралт



АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго:

Халдварт өвчин судлалын үндэсний төв болон зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд буюу алба, тасаг, ажлын байр /албан тушаал/-ны чиг үүрэг, холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, өнөөгийн байдлыг тодорхойлох, цаашид төвийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны төлөвлөлтийг боловсронгуй болгох, алба, тасаг нэгж болон ажлын байр /албан тушаал/-ны чиг үүргийн давхардлыг арилгах, тулгамдсан асуудлаар дүгнэлт, гаргах, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Хугацаа:

Хуанлийн 45 хоног

Эхлэх хугацаа:

2023 оны 10 дугаар сарын 20

Дуусах хугацаа:

2023 оны 12 дугаар сарын 04

Байршил:

Халдварт өвчин судлалын үндэсний төв

Зорилго	Халдварт өвчин судлалын үндэсний төв, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд буюу алба, тасаг, ажлын байр /албан тушаал/ тус бүрийн чиг үүрэг, холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, өнөөгийн байдлыг тодорхойлох, цаашид төвийн бүтэц, орон тооны төлөвлөлтийг боловсронгуй болгох, нэгж болон ажлын байр /албан тушаал/-ны чиг үүргийн давхардлыг арилгах, тулгамдсан асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж бүхий судалгааны тайланг боловсруулахад оршино.
Үндэслэл	Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.16-д “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг улсын болон бүсийн хэмжээнд төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах чиг үүрэг бүхий байгууллага байна.”, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн Төвийн эрх, үүрэг гэсэн Гурав дахь хэсгийн 3.1.2-д “Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж, холбогдох журам, дүрмийн дагуу захиран зарцуулах” гэж заасан байна. Эрүүл мэндийн тухай хуульд заасан төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн нийтлэг болон Халдварт өвчин судлалын үндэсний

	<p>төвийн дүрмийн 1.1-д заасан халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэг тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх асуудлын шинжилгээ, судалгааг хийх бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн чиг үүрэг, эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, бүтэц, зохион байгуулалт, нэгжүүд болон Ажлын байр /албан тушаал/-ны чиг үүргийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг судалж, үнэлгээ, дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж, санал боловсруулах судалгааны ажлыг хийх шаардлагатай байна.</p>
<p>Ажлын хамрах хүрээ</p>	<p>Үндэсний ажил мэргэжлийн тодорхойлолт, Халдварт өвчин судлалын бүтэц, чиг үүрэг, алба, тасаг нэгж, албан тушаалын чиг үүргийн баримт бичгүүд, Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль тогтоомжийг хамарна.</p>
<p>Цар хүрээ</p>	<ol style="list-style-type: none"> 1.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагаа, чиг үүргийг тогтоосон холбогдох хууль тогтоомжийн зохицуулалт болон төв, нэгж, ажлын байр /албан тушаал/-ны чиг үүргийг тогтоосон баримт бичгийг түүвэрлэн нэгтгэх; 2.Түүвэрлэсэн эх сурвалжид үндэслэн төвийн чиг үүрэг, нэгжийн чиг үүрэг, ажлын байр /албан тушаал/-ны чиг үүргийн хуваарилалт, давхардал, хийдэл байгаа эсэхийг шинжлэн судалж, дүн шинжилгээ хийх; 3.Төвийн нэгжийн чиг үүрэг, Ажлын байр /албан тушаал/-ны чиг үүрэг, холбогдох эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгаа эсэх талаар судалгаа хийж, анхаарах асуудлыг тодорхойлох; 4.Судалгаанд үндэслэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үр нөлөө бүхий санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах; 5.Судалгааны тайланг нэгтгэн боловсруулж, хэвлэн, холбогдох судалгаа, шинжилгээний материалын хамт хүлээлгэн өгөх;
<p>Зөвлөхөд тавигдах шаардлага</p>	<p>Ерөнхий шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Үнэлгээ, судалгаа, шинжилгээний ажил 3-аас доошгүй жил эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, өмнө нь байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн төсөл боловсруулж байсан туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай, байгууллагын үйл чиг үүрэг, хүний нөөц, хууль тогтоомжид үнэлгээ, шинжилгээ хийх, санал, дүгнэлт боловсруулах чадвартай судлаач бүхий төрийн болон төрийн бус байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байх; • Өмнө нь байгууллагын чиг үүрэг, хүний нөөц, хууль тогтоомжийн иж бүрэн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажил гүйцэтгэж байсныг

	<p>давуу тал гэж үзнэ.</p> <p>Бусад шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Дүн шинжилгээ хийх-тоон ба чанарын судалгаа хийх; • Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн төсөл, тайлан, бичиг баримт боловсруулах; • Хэлэлцүүлэг, сургалтад танилцуулга мэдээлэл хийх, дадлага туршлагатай байх; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчихөөргүй байх.
Тайлангийн хуваарь	<ul style="list-style-type: none"> • Гэрээ байгуулж ажил гүйцэтгэж эхэлсэн өдрөөс хойш хуанлийн 7 хоног тутамд ажлын явц, үр дүнг тайлагнаж байна.
Хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Ажлын даалгаврын дагуу боловсруулсан тайлан, судалгааны материал, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хандсан зөвлөмжийн төсөл байна.
Гүйцэтгэх ажлын шаардлага	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажлын эх нь Монгол хэл дээр бичигдсэн байна. • Судалгааны ажил нь агуулгын хувьд харилцан уялдаатай, иж бүрэн, шинжлэх ухааны судалгааны тодорхой арга зүй /түүвэрлэх, нэгтгэх, анализ хийх, загварчлах, харьцуулах зэрэг/-д үндэслэсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн, онол-практикийн ач холбогдол бүхий байна. • Судалгааны ажил /тайлан, төсөл, судалгаа, санал зөвлөмж/-ын хэлбэржүүлэлт /формат/ нь төрийн албан хэрэг хөтлөлтийн журам, судалгааны ажилд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн, хэл зүйн болон утга найруулгын алдаагүй байна.
Төлбөрийн нөхцөл	<p>Ажлын хөлсийг ажлын үр дүнд үндэслэсэн хэлбэрээр, гэрээнд заасны дагуу ажлын даалгаврын гүйцэтгэлээр төлнө. Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.</p>
Санал ирүүлэх	<p>Шалгаруулалтыг зөвлөх сонгох аргаар явуулна. Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн www.tender@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт /албан бичгээр/; • Үнийн санал, ажил гүйцэтгэх хуваарь; • Ажлын даалгаврыг гүйцэтгэх бүрэлдэхүүний CV; • Судалгааны ажил гүйцэтгэсэн дадлага, туршлагыг нотлох тодорхойлолт, холбогдох баримт бичиг;